



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/52

Номгон


Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй
боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх
ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх
хөтөлбөрийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 115 дугаар тогтоолоор баталсан Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлж, хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Архивын тасаг (В.Эрдэнэчимэг)-т, дагаж мөрдөж ажиллахыг нийт байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав) -т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642310127

D:\2023 on\захирамж-2023\Захирамж-2023 он.docx